



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/412

Булган сум

### Нийлүүлэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Экскаватор авах (Хялганат тосгон)” нийлүүлэгчээр шалгарсан “Цэ-Ус” ХХК-тай 87,400,000 (наян долоон сая дөрвөн зуун мянган) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчны газрын дарга (А.Гантөмөр)-д олгосугай.

2.Нийлүүлж буй бараанд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авч данс бүртгэлд бүртгэж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Хялганат тосгоны захирагч (П.Отгондаваа)-д үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан барааг холбогдох хууль, журам, стандарт, техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлж хүлээлгэн өгөхийг “Цэ-Ус” ХХК-ийн гүйцэтгэх захирал (М.Хашмаргад)-д даалгасугай.

4.Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг хавсралтаар баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5.Тус барааны санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Sugaг Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010573

Аймгийн Засаг даргын 2025 оны  
06 дугаар сарын 12-ны/ний өдрийн  
А/41.2 дугаар захирамжийн хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Б.Ариунболд
2	Баталгаат хугацаа	1 жил	П.Отгондаваа